

ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ “УВС АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”

Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (2017-2026), Аймгийн Засаг даргын “Манай -Увс” хөтөлбөр (2016-2020), Эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгүүд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Орон нутгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” үндсэн зарчим дээр үндэслэн Увс аймгийн Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх “Дэд хөтөлбөр”-ийг боловсрууллаа.

Нэг. Ерөнхий мэдээлэл

Увс аймаг нь 81377 хүн амтай. Аймгийн төв болох Улаангом суманд 30.7 мянган хүн ам оршин суудаг. Тус аймаг нь 21494 өрхтэй буюу нийт өрхийн 39.9 хувь нь малчин өрх байна. Нийт хүн амын 50.3 хувийг эрэгтэйчүүд, 49.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн ам зүйн насжилт нь 2016 оны байдлаар 32.9 хувийг буюу 26.8 мянган 0-14 насны хүүхэд, 61.8 хувийг буюу 50.3 мянган хөдөлмөрийн насны хүн ам, 5.3 хувийг буюу 4.3 мянган өндөр настан хүмүүс эзэлж байна. Аймгийн эдийн засгийн хувьд 2016 онд 322092.8 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) үйлдвэрлэсний 39.2 хувийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, 20.9 хувийг аж үйлдвэр барилгын, 39.9 хувийг худалдаа, үйлчилгээний салбараас оруулсан байна. 2016 онд аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 3982.0 мянган төгрөг болж өнгөрсөн оноос 246.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлого, Үндэсний хөтөлбөр, стратегиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн хүн амын эрүүл мэндийн асуудлыг сайжруулах зорилгоор Нөхөн үржихүйн загвар эмнэлэг, давсны хэрэглээг бууруулах, амны хөндийн эрүүл мэнд, осол гэмтэл, хавдарын өвчлөлийг бууруулахаар “Давсны хэрэглээг бууруулах”, “Сүү”, “Чихэр хийжүүлсэн ундааны зохисгүй хэрэглээг бууруулах”, “Сувилахуйн шинэчлэл” зэрэг хөтөлбөрүүд алслагдсан багт амьдардаг иргэдэд үйлчлэх “Баг-83 Нийгмийн цогц тусламж үйлчилгээ”, зорилтот бүлэгт чиглэсэн “Эрт илрүүлэг” үзлэг 2-17 насны хүүхдийн шүдний эмгэг, цоорлыг тогтоож, эмчлэх, цоорлоос сэргийлэх “Сийлант” төсөл, “Эрүүл элэг” хөтөлбөрийг санаачлан, амжилттай хэрэгжүүлж байна.

Орон нутгийн хэмжээнд дараах тулгамдсан асуудлууд байна.

- ✓ Нас баралтын тэргүүлэх шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хорт хавдар, осол гэмтэл, хоол боловсруулах, амьсгалын, перинаталь үеийн эмгэг тус тус эзэлж байна.
- ✓ 2011-2015 онд цочмог халдварт өвчин 2330, бэлгийн замаар дамжих халдвар 1157, сүрьеэгийн 300 тохиолдол тус тус бүртгэгдэж, өмнө нь бүртгэгдэж байгаагүй хачигт халдвар гарч, тэмбүү болон төрөлхийн тэмбүүгийн тархалт, цочмог халдварт өвчний дэгдэлтийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа тул халдварт өвчний бэлэн байдлыг хангаж, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог боловсронгуй болгох, чадавхижуулахад хүний нөөц, байр, тоног төхөөрөмжөөр хангах нь нэн тэргүүний тулгамдсан асуудал болж байна.
- ✓ Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 30 гаруй хувь нь эрхтэн тогтолцооны эмгэг, суурь өвчтэй үүнээс бөөр шээсний зам болон зүрх судасны өвчин дийлэнх хувийг эзэлж байгаа нь жирэмслэлт, төрөлт, төрөлтийн дараах хүндрэлд хүргэх гол хүчин зүйл болохын

зэрэгцээ 20 хүртэлх насны охидын жирэмслэлт, БЗДХ-ын тохиолдол нэмэгдэж байгаа нь эрүүл мэндийн салбарын анхаарах асуудлыг нэг болж байна.

✓ Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн тэргүүлэх шалтгааныг амьсгал, хоол боловсруулах, мэдрэлийн тогтолцооны эмгэг, осол гэмтэл, төрөлхийн хөгжлийн гажиг зэрэг өвчин эмгэгүүд эзэлж байна.

✓ Өрхийн эрүүл мэндийн төвд нэг иргэнд ногдох зардлаар тооцон санхүүжилтийг олгодог хэдий ч энэхүү санхүүжилтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулахаас гадна бусад урсгал зардал, эмнэлгийн бүхий л үйл ажиллагаанд зарцуулдаг тул стандартын дагуу хүний нөөцийг бүрдүүлэх, тусламж үйлчилгээг үр ашигтай, цогц, тасралтгүй үзүүлэхэд хүрэлцэхгүй байна.

✓ Энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулахдаа хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс, иргэдийн эрүүл мэндийн эрхэм чухал хэрэгцээ, тусламж үйлчилгээний тулгамдсан асуудлууд түүнийг шийдэх гарц, боломжийн талаарх төр, хувийн хэвшлийн шат, шатны эмч, мэргэжилтнүүд, иргэдийн санал, Монгол Улсын Засгийн газрын эрүүл мэндийн талаарх үзэл баримтлал, салбарын шинэчлэгдсэн бодлого чиглэл, аймгийн зорилт, хөтөлбөр, олон улсын байгууллагуудын чиг хандлага, үзэл баримтлалыг судалсан болно.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал:

2016 оны байдлаар нэгдсэн эмнэлэг-1, сум дундын эмнэлэг-3, сумын эрүүл мэндийн төв-15, өрхийн эрүүл мэндийн төв-4, хувийн ортой эмнэлэг-4, үүдэн эмнэлэг-9, рашаан сувилал-1, эмийн сан-18, эм ханган нийлүүлэх байгууллага-5, хилийн цэргийн ангийн эмнэлэг-2 нийт 62 эрүүл мэндийн байгууллага эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Стационарт 18795 хүн эмчлэгдсэнээс дундаж ор хоног 6.7, орны эргэлт 35.1, орны фонд ашиглалт 234.9 байна. Аймгийн хэмжээнд 17585 дуудлага ирснээс 19.4% -г алсын дуудлага эзэлж байна. Яаралтай тусламжийг сумдад нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн эмч нар хүрч үйлчилдэг бөгөөд хамгийн хол алслагдсан сум нь аймгийн төвөөс 350 км-ийн зайд оршдог, зам нь бартаатай учир эмнэлгийн тусламж үйлчилгээ 10-12 цагийн дараа хүрдэг зэрэг бэрхшээлээс гадна газар нутгийн хувьд тархай бутархай байрлалтай, ялангуяа өвлийн цас зудтай үед эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэхэд сөргөөр нөлөөлж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Аймгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалж эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан ажиллаж, чанартай тусламж үзүүлснээр хүн амын амьдралын чанарыг сайжруулж, дундаж наслалтыг уртасгах, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1. Иргэдийн эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн төрөл, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл, соёлын ялгаанаас үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх

2. Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байх

3. Нотолгоонд суурилсан, орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байх

4. Сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх

5. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх

6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүх нийтийг тэгш хамруулах, хэнийг ч орхигдуулахгүй байх

7. Эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сурталчилгааг хөгжүүлэх

Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 5 жилээр буюу 2017-2021 оноор төлөвлөн хэрэгжүүлж, явцын үнэлгээ хийн дараагийн үе шатанд төлөвлөлтийг шинэчлэн боловсруулж, үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД

Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн, нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллах.

1.1 Аймаг орон нутгийн онцлогт тохируулан бүтэц орон тоогоор ханган, санхүүжилтийг үйл ажиллагаанд уялдуулан нэмэгдүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийн төвийг чадавхжуулах.

1.2 Аймаг болон сум бүрт эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэн, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоогоор хангах.

1.3 Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоонд тулгуурлан хөгжүүлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулан, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх.

1.4 Орон нутгийн бодлогын баримт бичигтэй байгууллагын стратеги төлөвлөгөөг уялдуулж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

1.5 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нийгмийн эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, чадавхжуулах.

Хүрэх үр дүн: Орон нутгийн түвшинд салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч, хүн амын эрсдэлт зан үйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдсэн байна.

Зорилт 2. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлэн, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлэх.

2.1 Халдварт өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог боловсронгуй болгон чадавхжуулах.

2.2 Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах, хянах, сэргийлэх үйл ажиллагааг цогцоор нь шийдвэрлэн, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулахад орчин үеийн арга, технологийг ашиглах.

2.3 Аймагийн хэмжээнд байгалийн голомтот, зоонозын халдарт өвчнөөс хүн амыг сэргийлэх, тэмцэх, тархвар судлалын иж бүрэн арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах.

2.4 Сүрьеэ, БЗДХ,ХДХВ/ДОХ-ын хавьтал илрүүлэлтийг нэмэгдүүлэх замаар халдварын тархалтыг хязгаарлан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүн амын онцлогт тохируулан зохион байгуулах.

2.5 Сум, өрхийн эрүүл мэндийн төв, багийн түвшинд уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах замаар сайн дурын болон нөхөн дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний голомтыг устгах, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт хариу арга хэмжээ шуурхай авах чадавхи бүрдэж, судалгаа, тандалт зохион байгуулах нөхцөл хангагдсан байна.

Зорилт 3. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг судлан, хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврын уялдаа холбоонд тулгуурлан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

3.1 Анхан болон хоёрдогч шатанд халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, ЭМ-ийн тусламжийн шатлал хоорондын уялдаа холбоог сайжруулан хамтран ажиллах.

3.2 Бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах хөдөлгөөнийг дэмжсэн хамтлаг, клуб байгуулах, үүсгэл санаачлагыг дэмжин ажиллах.

3.3 Хүн амын өвчлөлийн бүлэг, насны онцлог, хүн ам зүйн үзүүлэлтээр халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааг зохион байгуулж, үр дүнд тулгуурлан нөлөөллийн аян эхлүүлэх.

3.4 Архи, тамхины хэрэглээг багасгах, цусны даралт, илүүдэл жинг бууруулах, таргалалтын хам шалтгааныг тодорхойлон, эрсдэлтэй бүлгийн хүн амд зориулсан сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх.

3.5 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэн, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилт, өвчлөлийн бүртгэл, хяналтын байдалд үнэлгээг зохион байгуулах.

3.6 Хүүхдийн байгууллагын хоолны газруудад зохистой хооллолтыг нэвтрүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.7 Аймгийн хэмжээнд “Элэг бүтэн-Увс”, “Давсны хэрэглээг бууруулах” зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Хүрэх үр дүн: Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл буурч, хүн амын дунд эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн хандлага нэмэгдсэн байна.

Зорилт 4. Мэдээлэл технологийн дэвшилтэд тулгуурлан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоо, орчин нөхцөлийг сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх.

4.1. Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтны идэвхи санаачилга, ажлын туршлагыг сайжруулах, тогтвортой ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин, хамтран ажиллах.

4.4. Анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, уялдаа холбоог сайжруулахад эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадварыг бэхжүүлэх.

Хүрэх үр дүн: Анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоо сайжирч иргэдийн сэтгэл ханамж дээшлэн, эмч эмнэлгийн мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажиллана.

Зорилт 5. Орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хамт олныг бүх талаар дэмжин, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, орчин үеийн олон хэлбэрийг ашиглан зохион байгуулж.

5.1. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын хамтын үйл ажиллагааг бэхжүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны үр дүнтэй бүтээлч харилцаа, түншлэлийг дэмжиж ажиллах.

5.2. Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, санхүүжилтийн механизмыг бий болгох.

5.3. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар салбар хоорондын хамтын үйл ажиллагааг зохицуулж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, гэр бүл, хамт олны үр дүнтэй бүтээлч харилцаа, түншлэлийг дэмжиж ажиллах.

5.4. Эрүүл мэндийн сайн дурын бүлгүүд, ажилтнуудыг сургах чадавхжуулах, идэвхжүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

5.5. Сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх хөдөлгөөн, аяныг өрнүүлэх, “Ирээдүйн босго” төвийн үйл ажиллагааг идэвхжүүлж, сургуулийн эрүүл аюулгүй орчныг бий болгох.

5.6. Шинээр гэр бүл болж байгаа залуу хосыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, үрэвсэлт өвчнийг оношлох, эмчлэх чадавхийг сайжруулан, тэдэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшлэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа бэхжинэ.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд уялдуулан зохион байгуулах, тусламж үйлчилгээг хөгжүүлэх.

1.1 Хүн амын эрэлт хэрэгцээ, аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байршил, хамрах хүрээ, зураглалыг шинэчлэх.

1.2 Нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний үзлэг оношилгоог сумын ард иргэдэд, шаардлагатай хүн амд нүүдлийн /явуулын/ амбулаторийн үйлчилгээний багцыг тодорхойлж хэрэгжүүлэх.

1.3 Хүүхдийн эмчийн хангалтыг сайжруулж, нярайн сэхээн амьдруулах, мэс заслын эмч бэлтгэж, мэргэшсэн эмч тусламжийг үзүүлдэг болох.

Хүрэх үр дүн: Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, ил тод, хариуцлагатай, үр дүнтэй, хүн төвтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээний тогтолцоо бүрдсэн байна.

Зорилт 2. Өрх сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдийг шаардлагатай оношилогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг үе шаттайгаар хангаж, эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэн, эмчилгээ үйлчилгээ авах чирэгдлийг багасгах.

2.1 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг оношилогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, ялангуяа яаралтай тусламж, хэвлийн ЭХО аппарат, лаборатори, нөхөн сэргээх оношилгоо, эмчилгээний нэн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор бүрэн хангах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.

2.2 Гэмтлийн тасгийг өргөжүүлж мэс заслын хагалгааны өрөө, болон С-ARM/ зөөврийн рентген аппарат/, Дерматоми /арьс нөхөх/ гэмтлийн хагалгааны иж бүрдэл багажаар хангах.

2.3 Сум, өрхийн багийн эмч, эх баригчдыг эх, нярайн яаралтай болон нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний урт, богино хугацааны сургалтанд хамруулж, дадлагажуулах.

Хүрэх үр дүн: Орчин үеийн оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, мэргэшсэн эмч мэргэжилтнүүдийн тоо нэмэгдэн эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.

Зорилт 3. Өмчийн хэлбэрээс үл хамааран орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг үйл ажиллагааны нэгдмэл байдлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болгох.

3.1 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай дотор, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн шүд, хүүхэд ба нярайн амбулатори, мэс заслын тусламж үйлчилгээний ачаалал хуваалцах, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, төлөвлөлт болон хэрэгжилтэнд хөндлөнгийн үнэлгээг хийж ард иргэдэд тайлагнадаг болох.

3.3 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслэлээр тогтвортой хангах нөхцлийг бүрдүүлж, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах.

Хүрэх үр дүн: Анхан шатны болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг чадавхижуулах замаар нэгдсэн эмнэлгийн ачаалал, хүлээгдэл чирэгдлийг бууруулна.

Зорилт 4. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулан эмнэлгийн тусламж үйлчилгээний чирэгдлийг бууруулах “Үйлчлүүлэгч төвтэй” байж, тусламж, үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан бие даасан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлэх.

4.1 Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх багцыг хэрэгжилтэнд хяналт тавих.

4.2 Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тасагт 4D ЭХО аппарат багаж, тоног төхөөрөмж, Сурфактант эмийн эмчилгээгээр хангах.

4.3 Багийн эмчийг явуулын байртай, багийн эмчийн цомогтой болгож, иргэдэд хүрч үйлчлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Алсын зайн оношилгоог хөгжүүлж, эрүүл мэндийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо, шуурхай байдал сайжирч, иргэдийн чирэгдэл буурсан байна.

Зорилт 5. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилогоо эмчилгээний үр дүн, тасралтгүй байдлыг хангах, байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлэн сэргийлж болох өвчний хүндрэл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтыг бууруулах.

5.1 Хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж байгаа халдварын бус архаг өвчний оношилгоо, эмчилгээний үр дүнг тооцох.

5.2 Халдварын бус өвчин ялангуяа өвчлөл нас баралтаар тэргүүлж буй зүрх судасны өвчин, тархины цус харвалт, хорт хавдар, осол гэмтэл зэрэг өвчлөл, нас баралтад судалгаа хийх, хариу цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

5.3 Эрт илрүүлэг, эмчилгээ, хяналт, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлж, хөдөлмөрийн чадвар алдалт, өвчлөл, сэргийлж болох нас баралт буурсан байна.

Зорилт 6. Тусламж үйлчилгээний анхан болон лавлагаа шатлалд уламжлалт анагаах ухааны оношилогоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх.

6.1 Ахмадын сувилал байгуулна. Тусламж үйлчилгээг өргөжүүлэх.

6.2 Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх, шаардлагатай эм хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.

6.3 Орон нутгийн байгалийн баялагт түшиглэн, эмчилгээний үр дүн сайтай рашаан, элс, шавар эмчилгээний сувилалуудыг дэмжиж ажиллах, сурталчлах.

Хүрэх үр дүн: Уламжлалт анагаах ухааны эмчилгээ оношилгоог орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх орчин бүрдэж, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн байна.

Зорилт 7. Сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

7.1 Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэх өдрийн эмчилгээ, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээ, гэрээр үзүүлэх асаргаа сувилгаа, сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, даатгалаас санхүүжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх.

7.2 Эрүүл мэндийн байгууллагад сэтгэл зүйч, хоол зүйч, хөдөлгөөн засалч, сэргээн засалчыг гэрээгээр, цаашид орон тоогоор ажиллуулах асуудлыг шийдвэрлэх.

7.3 Сувилахуйн жишиг үйлчилгээ бүхий загвар эмнэлгүүдийг шат дараатайгаар бий болгох, хөгжүүлэх.

7.4 Хүүхдүүдийн сувилал, хоолны газар байгуулж, суурь эмгэгтэй бага насны хүүхдийг стандартын түвшинд сувилах, нэмэгдэл хоолоор хангах нөхцөлийг бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Улсын жишигт хүрсэн хөнгөвчлөх, сэргээн засах болон сувилахуйн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлсэн байна.

Зорилт 8. Орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэргэшсэн эмч нарыг сургаж чадавхижуулах замаар зарим шаардлагатай тусламж, үйлчилгээг аймаг орон нутагт үзүүлдэг болох.

8.1 Ходоодны хеликобактерийн эрт илрүүлгийн үзлэг, оношилгоонд ард иргэдийг үе шаттайгаар хамруулах, өвчтэй илрэгсдийг хяналтанд эмчлэн эрүүлжүүлэх.

8.2 Элэгний С, В вирусийн эмчилгээг хийж, хянах урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох.

8.3 Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг тасралтгүй сургаж хөгжүүлэн мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлж, тусламж үйлчилгээний нотолгоонд суурилсан шинэ, технологийг хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн: Орон нутагтаа чанартай оношилогоо, эмчилгээ авах боломжийг бүрдүүлэн, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлснээр тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

Зорилт 9. Судалгаа, эрдэм шинжилгээг хөгжүүлэх, дотоодын сургалтын баазыг бэхжүүлэх.

9.1 Нэгдсэн эмнэлгийг сургалтын бааз эмнэлэг болгон хөгжүүлэх.

9.2 Судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, хөшүүргийг бий болгох.

9.3 Жил бүр эрдэм шинжилгээний эмхтгэл хэвлүүлэх, “Мэргэжилтэн бүр судлаач” байх чадварыг бий болгох.

Хүрэх үр дүн: Сургалтын бааз бүрдэн, судалгаа шинжилгээ хийж, эмнэлгийн мэргэжилтэнг сургах, бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зохицуулах чадавхи бүхий салбар болно.

Зорилт 10. Тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхижуулж, иргэд, олон нийтийн оролцоог дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг судлан, эх хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

10.1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлэх.

10.2. Эх хүүхдэд ээлтэй /баг, сум, хороо, хамт олон, аж ахуй нэгж/ байгууллага шалгаруулж, үйл ажиллагааг нь сурталчилж, хамтарч ажиллах замаар “Эх, хүүхдэд ээлтэй” орчинг бүрдүүлэх.

10.3 Жирэмсэн эмэгтэй бүрт эрүүл мэнд, нийгэм, орчны үнэлгээ хийж, шаардлагатай тусламж үйлчилгээг багаар үзүүлж, төрөлтөнд бэлтгэх шинэ тэргүүн аргыг хэрэгжүүлэх.

10.4 “Эх, хүүхдийн эргэлт, хяналт, эрүүлжилт нь бүх нийтийн үйл хэрэг” аяны болзол зарлаж хэрэгжүүлэх.

10.5 Эх нярайн эмнэлгийн тусламж үйлчилгээний нэг удаагийн хэрэгслэлээр тасралтгүй хангах.

Хүрэх үр дүн: Эх хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бусад эрхзүйн баримтын хэрэгжилтийн шалгуур хангагдана.

ХҮНИЙ НӨӨЦ

Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог шинэчилж, сургалтын түшиц эмнэлэгтэй болох

1.1 Аймгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулахын тулд эмнэлзүйн сургалт удирдах эмч, багш бэлтгэн авах ажлыг үе шаттай зохион байгуулж сургах, сургалт явуулах эрх зүйн болон сургалтын орчин нөхцөлийг сайжруулахын тулд мэргэжлийн болон төслийн байгууллагатай хамтран ажиллах

1.2 Аймгийн хэмжээнд нэн шаардлагатай төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааг гаргаж, сум орон нутгаас бэлтгэн сургах асуудлыг орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх, гэрээгээр сургах, захиалан бэлтгэх байдлаар шийдвэрлэх.

1.3 Шинээр төгсөж ирсэн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг нэн шаардлагатай чиглэлээр ажлын байранд дагалдуулан сургаж дадлагажуулах ажлыг жил бүрийн сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

1.4 Орон нутагт эмч, сувилагч солилцоог нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хийж үр дүнг тооцон ажиллах.

Хүрэх үр дүн: Аймгийн хэмжээнд шаардлагатай төрөлжсөн мэргэжлийн тусламжийг үзүүлэх чадавхи сайжирч, эмч мэргэжилтнээр тогтвортой хангагдан өөрийн орон нутагт төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах нөхцөл бүрдэнэ.

Зорилт 2 Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтныг өндөр хөгжилтэй оронд бэлтгэх, гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих

2.1 Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг гадаад улсад үе шаттайгаар суралцуулах, туршлага солилцуулах үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр хамтын ажиллагаанд үндэслэн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж чадавхижуулах

2.2 Эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж өндөр хөгжилтэй оронд урт болон богино хугацааны сургалтанд хамруулж чадавхижуулах

Хүрэх үр дүн: Сургалтын хэрэгцээ шаардлагыг харгалзан төгсөлтийн дараах сургалтыг гадаад улс оронд хийлгэж, эмч мэргэжилтнийг чадавхижуулснаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.

Зорилт 3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг мэргэжлийн уламжлал, хувь хүний хандлагад тулгуурлан мэргэжлээрээ ажиллах бүх хугацаанд төлөвшүүлэх, эрүүл мэндийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах.

3.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг төлөвшүүлэх сургалтыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад үе шаттай зохион байгуулах, эмч мэргэжилтнийг ажилд авах, ажиллаж байгаа эмч мэргэжилтний ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтэнд ёс зүйн шалгуур үзүүлэлтийг заавал оруулах

3.2 Эмнэлгийн мэргэжилтний үүрэг хариуцлагыг өндөржүүлж, харилцаа хандлагыг өөрчилж, “Ёс зүйг дээдлэгч хамт олон”, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдыг шалгаруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тэдний туршлагыг эмнэлгийн байгууллагуудад түгээн дэлгэрүүлэх

3.3 Мэргэжлийн байгууллага болон төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтний ёсзүй, харилцаа хандлагын судалгааг хийж үр дүнг тооцож ажиллах.

Хүрэх үр дүн: Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын ёс зүй, харилцаа хандлагыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлснээр эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа хандлага дээшилж, иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. Эмч мэргэжилтний мэргэжлийн болон ёс зүйн алдаа зөрчлийн тоо буурна.

Зорилт 4 Эрүүл мэндийн ажилтны цалингийн шатлал, албан тушаалын ангилал, зэрэглэлийг ажлын ачаалал, гүйцэтгэл, хариуцлага, үзүүлж байгаа тусламж үйлчилгээний төрөл, онцлогтой уялдуулан тогтоох хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэх.

4.1 Баг, сум, өрхийн ЭМТ болон СДЭ, АНЭ-н эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал, мэргэжлийн онцлог, ажиллаж байгаа ажлын байрны үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж цалинг ажлын үр дүнтэй уялдуулан олгох асуудлыг судалж саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх

4.2 Эмч, мэргэжилтний мэдлэг ур чадвар ажлын ачаалал, ёс зүйд харгалзан цалингийн урамшууллын механизм бий болгож ажиллах

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн ажилтны цалингийн шатлал, албан тушаалын ангилал, зэрэглэл нь ажлын ачаалал, гүйцэтгэл, хариуцлага, үзүүлж байгаа тусламж үйлчилгээний төрөл, онцлогтой уялдан хөдөлмөрийн норм, норматив шинэчлэгдэж эмч мэргэжилтнүүдийн урамшууллын механизм бий болно.

Зорилт 5 Эмнэлгийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулж хамт олон, нутгийн захиргааны байгууллагын оролцоо, хамтын ажиллагааны болон салбарын хөдөлмөр нийгмийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхээс гадна эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, эрүүл мэндийн ажилтныг ажлын байрны эрсдэлээс хамгаалах, мэргэжлээс шалтгаалсан өвчин, нас баралтыг бууруулах.

5.1 Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтний ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн байдалд аймгийн мэргэжлийн хяналтын хэлтэс /алба/-тай хамтран үнэлэлт өгч, эрүүл мэндийн ажилтныг ажлын байрны эрсдэлээс хамгаалах ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах.

5.2 Мэргэжлээс шалтгаалах өвчний судалгааг нарийвчлан гаргаж, нөлөөллийн байдалд үнэлэлт дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, ажлын байран дээр халдварт өртөх зэрэг эрсдийг бууруулах.

5.3 Орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон ИТХ-тай хамтран Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй ажиллагсдын нийгмийн асуудлыг судалж үе шаттайгаар сайжруулах арга хэмжээ авах /орон сууц, зээл, сургалтын төлбөр гм/, Эмнэлгийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн: Эмнэлгийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сайжирна.

Зорилт 1. Улсын нэгдсэн төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлыг 12 хувь, ДНБ-ний 5-аас доошгүй хувьд хүргэж нийт санхүүжилтийг нэмэгдүүлэх.

1.1. Аймгийн Эрүүл мэндийн салбарын төсвийг суурь судалгаанд үндэслэн төлөвлөж жил бүр үе шаттайгаар нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх.

1.2. Эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын цалинг эрүүл мэндийн салбарын үйлдвэрчний эвлэлийн хороо болон бусад эрх бүхий газруудад асуудал тавьж үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг төлөвлөх, хуваарилахдаа алслагдсан байдал, газар нутгийн онцлог, хүн амын тоо, өвчлөлийн байдлыг харгалзан хуваарилах, ялангуяа сумдын эрүүл мэндийн төвүүдийн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг ЭМСС, Сангийн сайдын 498/345 тоот тушаалын зардлыг үндэслэн хийж зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын цалин нэмэгдэж нийгмийн баталгаа хангагдана.

Зорилт 2. Эрүүл мэндийн салбарын нийт зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг 25 хувиас хэтрүүлэхгүй байх.

2.1. Тусламж үйлчилгээний хууль бус төлбөрөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.2. ЭМБ-ууд төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль эрхзүйн акт, хэм хэмжээг мөрдөж ажиллах.

Хүрэх үр дүн: Иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авах санхүүгийн эрсдэл бууруулна.

Зорилт 3. Эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авахад эрүүл мэндийн даатгалын үр дүн, үр ашиг бүхий санхүүжилтэд бүрэн шилжүүлж бүх нийтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах.

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх.

3.2. Эрүүл мэндийн даатгалын нэр төрлийг олшруулж, оношилгоо шинжилгээ, эмчилгээний чанар хүртээмжид тулгууралсан санхүүжилтын механизм бий болгох.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээ сайжирна.

Зорилт 4. Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн улсын төсвийн орцод тулгуурласан аргыг үр дүн, үр ашигт чиглэсэн, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хөшүүрэг бүхий санхүүжилтийн төлбөрийн аргад шилжүүлэх.

4.1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилтийн механизм бий болгох.

4.2. Улсын төсвөөс санхүүжих санхүүжилтийн хэмжээг үе шаттайгаар бууруулж эрүүл мэндийн даатгалаас санхүүжих санхүүжилтийг нэмэгдүүлэх.

4.3. Эрүүл мэндийн даатгалд хамрагдах иргэдийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Үр дүнд суурилсан санхүүгийн механизм бий болж, эрүүл мэндийн даатгалд хамрагдах иргэдийн тоо нэмэгдэнэ.

Зорилт 5. Эрүүл мэндийн салбарын нийт зардалд өрх, сумын эрүүл мэндийн төвийн буюу анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын эзлэх хувийг нэмэгдүүлж, нэг иргэнд ногдох зардлыг дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөж байгаа түвшинд хүргэх.

5.1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нэг иргэнээр тооцох зардлыг нэмэгдүүлэх.

5.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт нэмэгдэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирна.

Зорилт 6. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтэд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг оруулах.

6.1. Сум өрхийн эмнэлгийг эрүүл мэндийн даатгалд хамруулах.

6.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалаас санхүүждэг санхүүгийн механизм бий болгож тусламж үйлчилгээний нэр төрлийг олшруулж чанар хүртээмж дээшлүүлэх.

6.3. Өрхийн эрүүл мэндийн төвийн хууль эрхзүйн орчинг зохицуулах.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих механизм бий болон тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж чанар хүртээмж дээшилнэ.

Зорилт 7. Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлтэй уялдсан төлбөрийн механизм, санхүүгийн тайлагнахыг оновчтой болгох.

7.1. Мөнгөн кассын журмын дагуу төлбөрт үйлчилгээний орлогыг хуулийн хугацаанд төрийн сангийн дансанд төвлөрүүлж тушааж тайлагнах.

7.2. Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлд суурилсан эрүүл мэндийн санхүүжилтийн нэр төрлийг оновчтой болгох.

Хүрэх үр дүн: Бэлэн мөнгөний эрсдэл үүсэхгүй, эрүүл мэндийн санхүүжилтийн нэр төрөл, тайлагналаа тодорхой болно.

Зорилт 8. Салбарын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг эрүүл мэндийн салбарын технологийн үнэлгээ, салбарын тэргүүлэх чиглэл, хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд суурилан хэрэгжүүлэх.

8.1. Элэг бүтэн Увс, Цахим эрүүл мэнд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Сувилахуйн шинэчлэл дэд хөтөлбөр, Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллана.

8.2. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

8.3. “Баг-83” явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулна.

8.4. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 60 ортой хүүхдийн эмнэлэг, цогцос хадгалах байр, хог хаягдал түр хадгалах байр шинээр барьж, халдвартын тасаг, халаалтын төв шугамын траншейг их засварт, цусны банк, ариутгалын хэсгийг урсгал засварт оруулна.

8.5. Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасагт Гемодиализийн хэсэг нээж, эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулж хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

8.6. Малчин, Цагаанхайрхан сумдын эрүүл мэндийн төвийн барилгын их засвар, Өндөрхангай сумын сум дундын эмнэлгийн өргөтгөл, сумын эрүүл мэндийн төвүүдийн сантехникийн засвар үйлчилгээг үе шаттайгаар хийнэ.

8.7. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгад өргөтгөл хийж өдрийн болон гэрийн эмчилгээ сувилгаа, уламжлалт нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлнэ.

8.8. Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Сум дундын эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвийн авто машины парк шинэчлэл хийж, Зоонозын өвчин судлалын төвийг хээрийн шинжилгээний тандалт судалгааны мотоциклтой болгоно.

8.9. Баг бүрийг эмчтэй болгон сургаж, чадавхжуулан, унааны асуудлыг үе шаттайгаар шинэчилж “Багийн эмчийн цомог” зөөврийн үзлэгийн байр, утсан сүлжээгээр эргэх холбоо тогтоож ажиллана.

8.10. Сум дундын эмнэлгүүдийг мэс засал, мэдээгүйжүүлгийн багаж тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж, хагалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэн, Өмнөговийн сум дундын эмнэлгийг зайн оношилгоонд холбоно.

8.11. Анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг Эх нярайн цомог, бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сувилал ажиллуулна.

8.12. Аймгийн эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны дотоод, гадаадын сургалтанд үе шаттайгаар хамруулан чадавхжуулж, төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж тэдний туршлагаас суралцана.

8.13. Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн лабораторийн чадавхыг сайжруулж халдварт өвчин, байгалийн гамшиг, олныг хамарсан осол гэмтлийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай, оновчтой зөв зохион байгуулан, мэдээллийн шуурхай удирдлагын нэгж бий болгон, үр дүнг тооцон ажиллана.

8.14. Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээний тасгийг өргөжүүлнэ.

8.15. Нэгдсэн эмнэлэгт цогцос хадгалах байр шинээр барих

8.16. Зоонозын өвчин судлалын төвийн шинэ барилга, хээрийн шинжилгээний унааны асуудлыг шийдвэрлэх.

8.17. Анхан болон нэгдсэн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх ажлыг зохион байгуулах.

8.18. Зарим төрлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг дэмжиж хамтран ажиллах.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагын ачаалал буурч тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ

Зорилт 1. Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, эмнэлгийн тоног, төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээ, чанарын хяналт, баталгаажуулалт, ашиглалтыг сайжруулах.

1.1 Монгол улсын MNS 5095-стандартын дагуу бүх тасаг нэгжүүдийг шаардлагатай аппарат тоног төхөөрөмжөөр хангах.

1.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн баталгаажилт жил бүр хийлгэж ажиллах.

1.3 Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах.

1.4 Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийг бүртгэх нэгдсэн программд шилжих.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн тоног, төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээ, чанарын хяналт, баталгаажуулалт, ашиглалт сайжирч тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

Зорилт 2. Аймгийн хэмжээнд оношилж эмчлэхэд хүндрэлтэй байгаа зарим өвчнийг оношилох, эмчлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлэх асуудлыг судлан, шийдвэрлэх арга замыг боловсруулан, оношилгоо эмчилгээнд ахиц гаргах.

2.1 Нэгдсэн эмнэлгийн ариутгалын автоклав болон бусад тоног төхөөрөмж байрны шинэчлэл хийх.

2.2 Хүчилтөрөгчийн ханын системд холбох шаардлагатай тасаг нэгжийн судалгааг гаргаж, хүчилтөрөгчийн ханын системд холбох.

2.3 Нэгдсэн эмнэлгийн нян судлалын байр болон аппарат тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх.

2.4 Гемодиализын эмчилгээний өрөөг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

2.5 Нэгдсэн эмнэлгийн ходоодны дуранг засварлаж ажилд оруулах, орчин үеийн дурантай болгох.

2.6 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх, төсөвт суулгаж өгөх.

Хүрэх үр дүн: Орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, оношилгоо эмчилгээнд ахиц гарна.

ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааны үр ашгийг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.

1.1. Эмийн худалдан авалтын зохион байгуулалтын тогтолцоог сайжруулж, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулах, зарцуулалтад үнэлгээ хийж, үр дүнг тооцож, иргэдийн оролцоог бий болгож ил тод хариуцлагатай байдлыг бий болгох.

1.2. Тендерээр шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллагуудын эмийн нийлүүлэлтэд хяналт үнэлгээ хийж, гэрээ хангалтгүй үнэлэгдсэн байгууллагуудад мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн дараагийн үйл ажиллагаанд оролцох эрхийг шийдвэрлэх зарчимд шилжүүлж, хариуцлагыг өндөржүүлэх.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагууд эмчилгээний өндөр идэвхи бүхий эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдаж эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин бүрдэснээр, эмийн тусламж үйлчилгээний үр ашиг нэмэгдэж, хүртээмж сайжирна.

Зорилт 2. Хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, антибиотикийг эмчийн жороор олгох соёлыг бүрдүүлэх.

2.1. Эрүүл мэндийн байгууллага, иргэдийн дунд антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх.

2.2. Эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулах.

2.3. Эмийн жорын стандартын мөрдөлтийг сайжруулж, эмч, мэргэжилтнүүдийн антибиотик эмийг жороор бичих, олгох хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоог бий болгох.

2.4. Иргэдийн эмийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг өөрчлөх, антибиотикийг жороор олгох болон антибиотикийн зохистой хэрэглээнд иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Антибиотик эмийн зөв хэрэглээ нэмэгдэж, эмийн жорын бичилтийн хариуцлагын тогтолцоо бий болж, иргэдийн мэдлэг хандлага дээшилсэн байна.

Зорилт 3. Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааг тогтмол хийх, эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх.

3.1. Эм, эмнэлгийн хэрэгслэлийн чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, эмийн чанар, аюулгүй байдлын тандалт, судалгааг хийх механизм бүрдүүлэх.

3.2. Эрүүл мэндийн салбарт цахим жор нэвтрүүлэх, эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг сайжруулах

Хүрэх үр дүн: Эмийн чанар, аюулгүй байдлыг хянах тогтолцоо бүрдэж, цахим жорын системд шилжсэн байна.

Зорилт 4. Эмийн эргэлтийн сангийн одоогийн тогтолцоонд үнэлгээ хийж, цаашид хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох, хувийн хэвшлийн эмийн сангуудын үйл ажиллагаанд эрх зүйн хэрэгжилтийг хангаснаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.

4.1. Эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд үнэлгээ хийж статусыг тодорхой болгож хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах.

4.2. Эмийн сангуудын эмийн хангамж, нэр төрөл, эм, эмнэлгийн хэрэгслийн жижиглэн худалдаалах жишиг үнэ, даатгалын хөнгөлөлттэй үнээр үйлчилсэн байдал зэрэгт мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвлөмж гарган хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Эмийн эргэлтийн сангийн тогтолцоо тодорхойлогдож, эмийн сангуудын үйл ажиллагаа, үйлчилгээний соёл сайжирч, иргэдэд чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэн худалдаалах эмийн жишиг үнээр худалдаалах механизм бүрдсэн байна.

Зорилт 5. Клиникийн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал бүрт нэвтрүүлэх.

5.1. Нэгдсэн эмнэлэгт эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй оношилгоо, эмчилгээний стандартын мөрдөлтөд давхар хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх.

5.2. Нэгдсэн эмнэлэгт эмнэлзүйн эм зүйчийг сургаж чадавхижуулан орон тоогоор ажиллуулж үр дүнг тооцох.

Хүрэх үр дүн: Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээ өргөжиж, оношилгоо эмчилгээний удирдамж мөрдөлт сайжирсан байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА

Зорилт 1. “Цахим эрүүл мэнд” программыг суулгаж, ашиглалтанд нэвтрүүлнэ.

1.1. Нэгдсэн эмнэлэгт E-HEALTH програмыг нэвтрүүлж үйлчлүүлэгчийн мэдээллийг цахимд шилжүүлж цаасгүй эмнэлэг болох ажлыг эрчимжүүлэх

1.2. Нэгдсэн эмнэлгийн серверийн өрөөг стандартын дагуу тохижуулж, аюулгүй үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлж сургалт хийх нөхцөл боломжоор хангах.

Зорилт 2. “Шилэн эмнэлэг” төслийн хүрээнд өвчтөн, үйлчлүүлэгчдэд мэдээллийг ил тод хурдан шуурхай авах боломж нөхцөлийг бүрдүүлэх.

2.1. Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг яаралтай тусламжийн тасаг, Мэс засал, Төрөх тасгийн эмчилгээний өрөө, сахиурын өрөө хооронд онлайн харилцах боломжтой болгох.

2.2. Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг яаралтай тусламжийн тасаг, Мэс засал, Төрөх тасгийн хэвтэн эмчлүүлэгчийн мэдээллийг хүлээлгийн танхимд дэлгэц байрлуулах.

2.3. Төрсөн эх, хүүхдийн талаарх товч мэдээллийг урсдаг зарын самбараар үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх.

2.4. Амбулаторийн кабинетуудын үйлчлүүлэгчийн бүртгэл, үйлчлүүлэх дарааллыг нийтэд ил тодоор дэлгэцээр харуулах.

2.5. Нэгдсэн эмнэлгийн хяналтын камерын системийг шинэчлэх.

Зорилт 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх.

3.1. Хүүхдийн сэхээн, Эрчимт эмчилгээ сэхээн, Мэс засал, Төрөх тасгийн өрөөнүүдийг IP камер байршуулж 3-р шатлалын эмнэлгийн эмч нартай холбож зөвлөгөө хяналт хийх боломжийг бүрдүүлэх.

3.2. Эрүүл мэндийн газарт Шуурхай удирдлагын төв байгуулах.

Зорилт 4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламж чанар хүртээмжийг сайжруулах.

4.1. Баруунтуруун СДЭ, Хяргас, Тэс, Тариалан, Зүүнхангай ЭМТ-ийг шилэн кабел болон утасгүй интернет сүлжээнд интернет сүлжээнд холбох

4.2. Өмнөговь СДЭ, Зүүнхангай сумын ЭМТ-ийг телемедицин сүлжээнд холбож шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

4.3. Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг үе шаттайгаар “Мобайл технологи” нэвтрүүлэх

4.4. Мэдээлэл технологийн дэвшлийн ашиглан Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нэгдсэн эмнэлгийн зөвлөх эмч нараас зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх.

Зорилт 5. Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх.

5.1. Эрүүл мэндийн статистик мэдээг нэг урсгалаар нэгтгэн төвлөрүүлэх шинэчилсэн тогтолцооны саналыг боловсруулан, хэлэлцүүлэх.

5.2. Эрүүл мэндийн болон мэдээлэл, технологийн ажиллагсдын эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны талаарх мэдлэг, чадварыг сайжруулах.

5.3. Хяналт үнэлгээний хүрээг боловсруулах, хяналт үнэлгээ хийх мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг сайжруулах.

5.4. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын эрүүл мэндийн мэдээллийн санг бий болгож хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт ахиц гарч, хяналт хийх, мэдээ мэдээллийн ил тод, шуурхай байдал хангагдана.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллага, ажилтны эрх, үүргийн давхардлыг арилгах, үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах.

1.1. Эрүүл мэндийн салбарын ажилтны эрх үүрэг, манлайлал, менежментийн талаарх мэдлэг, чадварыг сайжруулах.

1.2. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын ажлын ачаалалд судалгаа хийх.

Хүрэх үр дүн: Ажлын ачааллыг бодитой тооцох боломжтой болно.

Зорилт 2. Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлгийг улс төрөөс хараат бус, хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалтай болгох.

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын өмчлөл, эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалтад хяналт тавих.

2.2. Хүн амын өвчлөлийн байдал, хэрэгцээнд суурилсан эмнэлгийн хөрөнгө оруулалтыг хийх.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тогтолцоо сайжирна.

Зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, судалгаанд тулгуурлан зохион байгуулах.

3.1. Хөдөөгийн багийн эмч нарыг ажлын ачааллыг тэнцвэржүүлэн, чадавхжуулж, хүн ам ихээр төвлөрсөн багийн төвийг их эмчийн салбарын статусаар ажиллуулах асуудлыг шийдвэрлэнэ.

3.2. Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлж хүний нөөц, багаж тоног төхөөрөмжөөр хангах.

Хүрэх үр дүн: Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.

Зорилт 4. Хоёр болон олон талт хамтын ажиллагааг салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах.

4.1. Сумдын засаг дарга, эрүүл мэндийн төвийн дарга болон эрүүл мэндийн газрын даргын хоорондын гурвалсан гэрээг жил бүр байгуулж үр дүнг тооцон ажиллах.

4.2. Аймаг орон нутагт ажиллаж буй эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, урамшуулж, харилцан туршлага солилцох, сурталчлах тогтолцоог бүрдүүлэх.

4.3. Хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангах асуудлыг дэмжин, гадаадын төсөл хөтөлбөрийн дэмжлэг авах.

Хүрэх үр дүн: Хамтын ажиллагаа сайжирч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудал шийдвэрлэгдэж, эмч мэргэжилтнүүд чадавхижиж санхүүжилт шийдвэрлэгдэнэ.

Зорилт 5. Бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

5.1. Төр, хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн бүх эмнэлэг, лабораториудын шинжилгээ, рентген, томографийн зураг, онош баталгаажилтыг харилцан зөвлөлдөх, ярилцах тогтолцоог сайжруулах.

5.2. Орон нутгийн өвчлөлийн чиг хандлага, төрийн эмнэлгийн ачаалалтай уялдуулан хувийн эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зохицуулах.

5.3. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагын багийг хамтын шийдвэр гаргах, багаар ажиллах ур чадварт сургах, удирдлагын менежмент, хууль эрх зүй, санхүүгийн чиглэлээр чадавхжуулах.

5.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах.

Хүрэх үр дүн: Улсын эмнэлгийн ачаалал буурч, тусламж үйлчилгээний хүлээгдэл багасч, удирдлагын менежмент сайжирна.

Зорилт 6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.

6.1. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын шийдвэр гаргалтад ил тод байдлыг эрхэмлэн хувь хүн, хамт олны саналыг тусгаж оролцоог хангаж ажиллах.

6.2. Эрүүл мэндийн үйлчилгээний ил тод байдлыг хангахад төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж хөндлөнгийн хяналтыг бий болгох.

6.3. Цахимаар бүртгэгдсэн иргэдийн мэдээллийг эмч, кабинет бүрээр иргэдэд нээлттэй мэдээлэлж байршуулах.

Хүрэх үр дүн: Иргэдийн оролцоо хангагдана, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирна.

шалгуур үзүүлэлт

Энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.2-т заасан зорилтын үе шатны зорилт болон хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан.

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2015 он)	Зорилтот түвшин (2021)	Мэдээллийн эх сурвалж
Нэг. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын				
1.1	Хүн амын дундаж наслалт (бодит тоо)	68.8	73	Үндэсний статистикийн хороо
1.2	Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд)	0.0	0.0	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.3	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	23.4	16.0	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.4	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	20.4	14.0	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.5	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд)	18.3	16	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.6	Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүн амд)	18.5	13	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.7	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь	97.6	99.0	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.8	Вирүст гепатитын өвчлөл (10000 хүн амд)	3.4	2.5	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
1.9	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (10000 хүн амд)	8.5	8.0	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
Хоёр. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого				
2.1. Нийгмийн эрүүл мэнд				
2.1.1	Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт, хувиар	58	80	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
2.1.2	Чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт, хувиар	46,2	70	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
2.1.3	Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт, хувиар	37,4	60	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
2.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ				
2.2.1	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дундаас дээш үнэлгээ үнэлгээ өгсөн үйлчлүүлэгчид	60	80	Түүвэр судалгаа
2.3. Хүний нөөц				
2.3.1	Эмч сувилагчийн харьцаа	1:1.6	1:2	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
2.4. Эрүүл мэндийн санхүүжилт				
2.4.1	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл			Эрүүл мэндийн

	мэндийн салбарын санхүүжилтын эзлэх хэмжээ, хувиар	2.1	4.0	статистик мэдээлэл
2.5. Эрүүл мэндийн технологи				
2.5.1	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, чанарын хяналт шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийж хэвшсэн эрүүл мэндийн байгууллага (хувиар)	6	60	Үнэлгээний тайлан
2.6. Эм зүйн тусламж, үйлчилгээ				
2.6.1	Зайлшгүй нэн шаардлагатай, эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан хувь	85	90	ЭМБ-ын тайлан
2.7. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага				
2.7.1	Алсын зайн үндэсний сүлжээнд хамрагдсан сумын эрүүл мэндийн төв	0	4	ЭМБ-ын тайлан
2.8. Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал				
2.8.1	Хагас бие даасан засаглалын хэлбэрт шилжсэн эмнэлэг	0	1	Эмнэлгийн тайлан

Санхүүжилт:

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлогдох бөгөөд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

Үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

1. Улсын болон орон нутгийн төсөв
2. Бусад зээл тусламж төсөл хөтөлбөрийн санхүүжилт
3. Төрийн бус байгууллага, хандивлагч.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээг жил тутамд, хөндлөнгийн үнэлгээг 2 жил тутамд хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан АИТХ-д тайлагнана. Хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг төсөвт тусгана.

Хөтөлбөрийн үр нөлөө

Хөтөлбөр хэрэгжүүлсний үр нөлөө нь хүн амын насжилт, амьдралын чанар, нийгмийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, олон талт хамтын ажиллагааны тогтолцоо бий болж “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-2030, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын нэгдүгээр үе шатны хэрэгжилтийг хангаснаар хэмжигдэнэ.

ХУРААНГУЙЛСАН ҮГИЙН ТАЙЛАЛ

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ОУБ	Олон улсын байгууллага
ХДХВ/ДОХ	Хүний дархлал хомсдолын вирус/дархлал олдмолын хам шинж
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
СДЭ	Сум дундын эмнэлэг
С,ӨЭМТ	Сум, Өрхийн эрүүл мэндийн төв
ТББ	Төрийн бус байгууллага
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМНДХ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс
ЭМСС	Эрүүл мэнд спортын сайд
ЭХНБ	Эм ханган нийлүүлэх байгууллага

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА

№	Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /МУИХ-ын 2016 оны 19-р тогтоол/	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /Засгийн газрын 2017 оны 24-р тогтоол/	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөгжлийн бодлого 2014-2023 он хэрэгжүүлэх стратеги 2015-2019 он ЭМС-ын тушаал 2014 он 55 тоот	Аймгийн Засаг даргын 2016 – 2020 онд хэрэгжүүлэх “МАНАЙ УВС” үйл ажиллагааны хөтөлбөр
Нийцэж байгаа зорилго, зорилт					
1	<p>Зорилго: Аймгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалж эрүүл мэндийн салбарын санхүүжилтын зохистой тогтолцоог бүрдүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан ажиллаж, чанартай тусламж үзүүлснээр дундаж наслалтыг уртасгах, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.</p>	<p>1.2 Нийгмийн тогтвортой хөгжил Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим Эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх;</p>	<p>Хоёр. Бодлогын зорилго, зарчим, зорилт 2.1. Бодлогын зорилго Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгахад оршино.</p>		<p>1.2 Эрүүл мэндийн чиглэлээр: Хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг салбарын тэргүүлэх чиглэл болгон иргэн бүрт эрүүл амьдрах зөв дадал, зан үйлийг төлөвшүүлж, хүний нөөцийн чадавхийг сайжруулан, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, хүчин чадлыг нэмэгдүүлснээр зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин, нялхсын эндэгдлийг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.</p>
2	<p>Зорилт-1. Нийгмийн эрүүл мэнд Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд нь тохирсон өвчний эрт илрүүлэг,</p>		<p>2.4. Бодлогын зорилтууд 2.4.1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр</p>		<p>1.2.1 Элэг бүтэн Увс, Цахим эрүүл мэнд, НҮЭМ, Сувилахуйн шинэчлэл дэд хөтөлбөр, Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллана.</p>

	хяналтын тогтолцоог бүрдүүлэх				
3	Зорилт-2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулж, тусламж, үйлчилгээний чирэгдлийг бууруулах;		2.4. Бодлогын зорилтууд 2.4.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр	Стратеги 1. Хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулж, эмнэлэгт хэвтүүлэн эмчлэхээс бусад үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, нотолгоонд суурилсан мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоог бэхжүүлнэ. Стратеги 2. Нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний үр дүнтэй арга, технологийг нэвтрүүлж, чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн эмнэлзүйн эрсдлийн удирдлага, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлнэ.	1.2.4 Аймгийн нэгдсэн эмнэлэгт 60 ортой хүүхдийн эмнэлэг, цогцос хадгалах байр, хог хаягдал түр хадгалах байр шинээр барьж, халдвартын тасаг, халаалтын төв шугамын траншейг их засварт, цусны банк, ариутгалын хэсгийг урсгал засварт оруулна. 1.2.12 Анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг Эх нярайн цомог, бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сувилал ажиллуулна.
4	Зорилт-3. Хүний нөөц Нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах хүрээнд хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх		2.4. Бодлогын зорилтууд 2.4.3. Хүний нөөцийн чиглэлээр		1.2.13 Аймгийн эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны дотоод, гадаадын сургалтанд үе шаттайгаар хамруулан чадавхжуулж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж тэдний туршлагаас суралцана.
5	Зорилт-4. Эрүүл мэндийн санхүүжилт Улсын нэгдсэн төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлыг 12 хувь, ДНБ-ний 5-аас доошгүй хувьд хүргэж нийт санхүүжилтийг нэмэгдүүлэх Эрүүл мэндийн нийт зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг 25 хувиас хэтрүүлэхгүй байх		2.4. Бодлогын зорилтууд 2.4.4. Эрүүл мэндийн санхүүжилтийн чиглэлээр	Стратеги 5. Эрүүл мэндийн даатгалын багцыг өргөжүүлж, гүйцэтгэл, чанар, үр дүнг дэмжсэн төсөвлөлт, хөрөнгө оруулалтын нэгдсэн зохицуулалт, цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.	1.2.6 Завхан, Цагаанхайрхан сумдын ЭМТ-н барилгын их засвар, Өндөрхангай сумын сум дундын эмнэлгийн өргөтгөл, сумын эрүүл мэндийн төвүүдийн сантехникийн засвар үйлчилгээг үе шаттайгаар хийнэ. 1.2.7 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгад өргөтгөл хийж өдрийн болон гэрийн эмчилгээ сувилгаа, уламжлалт нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлнэ. 1.2.8 Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн Зоонозын өвчин судлалын төв, Сум дундын эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвийн авто машины парк шинэчлэл хийж, Зоонозын өвчин суд

					лалын төвийг хээрийн шинжилгээний тандалт судалгааны мотоциклтой болгоно.
6	Зорилт-5. Эрүүл мэндийн технологи Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, эмнэлгийн тоног, төхөөрөмжийн засвар үйлчилгээ, чанарын хяналт шалгалт тохируулга, баталгаажуулалтын т огтолцоог бэхжүүлэх		2.4. Бодлогын зорилтууд 2.4.5. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр	Стратеги 6. Тусламж, үйлчилгээний ачаалал хуваалцах, өндөр технологи нэвтрүүлэх, дэд бүтцийг барьж байгуулах, дэмжих үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.	1.2.11. Сум дундын эмнэлгүүдийг мэс засал, мэдээгүйжүүлгийн багаж тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж, хагалгаа хийх орчин нөхцөлийг бүрдүүлэн, Өмнөговийн сум дундын эмнэлгийг зайн оношилгоонд холбоно.
7	Зорилт-6. Эм зүйн тусламж, үйлчилгээ Эмийн үйлдвэрт “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал”-ыг бүрэн нэвтрүүлэх		2.4. Бодлогын зорилтууд 2.4.6. Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр		
8	Зорилт-7. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлгийг улс төрөөс хараат бус, хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалтай болгох		2.4. Бодлогын зорилтууд 2.4.7. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлагын чиглэлээр	Стратеги 3. Үйлчилгээний тав тухтай орчныг бүрдүүлж, үйлчилгээний зохицуулалтын мэдээллийг үйлчлүүлэгчдэд ойлгомжтой, шуурхай хүргэх, сэтгэл зүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх тогтолцоог бүрдүүлнэ.	1.2.14. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн лабораторийн чадавхыг сайжруулж халдварт өвчин, байгалийн гамшиг, олныг хамарсан осол гэмтлийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай, оновчтой зөв зохион байгуулан, мэдээллийн шуурхай удирдлагын нэгж бий болгон, үр дүнг тооцон ажиллана.
9	Зорилт-8. Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал		2.4. Бодлогын зорилтууд 2.4.8. Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдлын чиглэлээр	Стратеги 4. Эмнэлгийн засаглалын бие даасан байдлыг сайжруулах эрхзүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн удирдлагын хариуцлага, ил тод байдлыг дэмжих олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	1.2.9. Эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг иргэн, төрийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааны оролцоотойгоор хийж салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэн үр дүнг тооцон ажиллана.
Нийцсэн (тоо, %)			100%	100%	100%
Тайлбар танилцуулга:					

ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
2017-2021 он

Зорилго		Аймгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалж эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан ажиллаж, чанартай тусламж үзүүлснээр хүн амын амьдралын чанарыг сайжруулж, дундаж наслалтыг уртасгах, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.									
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Хүн амын дундаж наслалт – 73 Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд) – 0.0 Жирэмсний эрт үеийн хяналтын хувь – 95.0 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) –16.0 Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) –14.0 Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) –16.0 Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) –13.0 Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь – 99.0 Вируст гепатитын өвчлөл (10000 хүн амд) –2.5 Сүрьеэгийн тохиолдлын түвшин (10000 хүн амд) –8.0									
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа					Санхүүжилт /мянган төгрөгөөр/
						2017	2018	2019	2020	2021	
Үйл ажиллагааны чиглэл 1.		НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД									
1.1. Нийгмийн эрүүл мэндийн салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн, нэгдсэн зохицуулалтаар хангаж, аймгийн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг бэхжүүлэх.											
1.1.1.	Хувь хүн, гэр бүл, хамт олонд хүртээмжтэй энгийн хэлбэрээр өөрсдийнх нь оролцоог нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн анхны тусламжийн үзүүлэх.	Анхны тусламжийн арга зүйг боловсруулсан байна.	Иргэдийн мэдлэгийн хувь	ЭМГ	ЭМГ, АНЭ, СДЭ, СЭМТ, ӨЭМТ	+	+	+	+	+	0,25
1.1.2.	Улс, салбарын хэмжээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичигтэй байгууллагын стратеги төлөвлөгөөг уялдуулан төлөвлөх, шинэчлэн зохион байгуулах, хянах, тайлагнах, үр дүнг тооцон ажиллах.	Салбарын бодлого, стратегийн чиглэлийн дагуу хөтөлбөрүүдийг уялдуулан боловсруулсан байна.	Стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.3
1.1.3.	Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өргөжүүлж, аж ахуй нэгж, байгууллага, хамт олны оролцоог нэмэгдүүлэх замаар эрүүл баг, сум, байгууллагын тоог нэмэгдүүлж сурталчлах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох.	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг жилд 1 удаа зохион байгуулсан байна.	ЭМЯ, ЭМГ	НЭ, СДЭ, СЭМТ, ӨЭМТ	+	+	+	+	+	0.6
1.1.4.	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаалын дагуу аймаг орон нутгийн онцлогт тохируулан бүтэц орон тоог бэхжүүлэн, санхүүжилтийг үйл ажиллагаанд уялдуулан нэмэгдүүлэх.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүтцийг боловсруулан	Бүтцийн хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+		+	+	+	0.3

		батласан байна.										
1.1.5.	Явуулын тусламж үйлчилгээний баг байгуулан, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.	Явуулын тусламж үйлчилгээний баг байгуулагдаж, үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Явуулын тусламж үйлчилгээг жилдээ 2-оос доошгүй удаа үзүүлсэн байна.	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.5
1.2. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлэн, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлэх												
1.2.1.	Халдварт өвчнийг бууруулах иргэдийн оролцоо, үр дүнд суурилсан аргачлалуудыг хэрэгжүүлж үр дүнг тооцох.	Халдварт өвчнийг бууруулах төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.2
1.2.2.	Тайван цагт бэлэн байдлыг хангуулах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцооны чадавхийг сайжруулахад тархвар судлагч нарыг бэлтгэх, чадавхжуулах.	Үе шаттай сургалтуудыг зохион байгуулж, бэлэн байдлын сантай болсон байна.	Жилдээ 2-оос доошгүй удаа сургалтыг зохион байгуулсан байна.	ЭМГ	СЗДТГ, СДЭ, СЭМТ, ӨЭМТ	+	+	+	+	+		18.0
1.2.3.	Сүрьеэгийн анхан тусламжийн чанарыг сайжруулах.	Сүрьеэгийн диспансерийн өрөө, тасалгааг стандартад нийцүүлэх ажлыг эхлүүлсэн байна.	Онош баталгаажилт 70%-д хүргэх, сүрьеэгийн эдгэрэлтийн түвшинг 85 %-аас дээш болно	ЭМГ, НЭМ	ЗДТГ	+	+	+	+	+		2.4
1.2.4.	Вируст гепатиттэй тэмцэх сэргийлэх ажлыг салбар хоорондын хамтын ажиллагаатай уялдуулах.	Элэг бүтэн Увс дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	АЗДТГ, ЭМГ, АНЭ	СЗДТГ, СДЭ, СЭМТ, ӨЭМТ, ХХЭМБ	+	+	+	+	+		24.0
1.2.5.	БЗДХ, ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, үр дүнг тооцон ажиллах.	Үйл ажиллагааны төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМГ, АНЭ	ААНБ-ууд	+	+	+	+	+		3.2
1.2.6.	Стандартын шаардлага хангасан лаборатори болон сэжигтэй өвчтнийг тусгаарлах байртай болох.	Шинэ ажлын байртай болж, үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+					920,0
1.2.7.	Хээрийн шинжилгээний тоноглогдсон иж бүрэн дэлгэмэл лаборатори, тоноглогдсон авто машин, хөдөлмөр хамгааллын иж бүрэн хувцас /өвлийн хувцас гудас, аяны хөнжил/ хэрэглэлээр хангах.	Иж бүрэн дэлгэмэл лаборатортой болсон байна.	Иж бүрэн дэлгэмэл лабораторын үйл ажиллагааны тайлан	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	СЗДТГ, СДЭ, СЭМТ, ӨЭМТ			+				7.5
1.2.8.	Байгалийн голомтод халдварт өвчний мэдээллийн сангийн үйл ажиллагааг баяжуулан байгууллагын вэб хуудастай нэгтгэж, бэхжүүлэх	Мэдээллийн сантай болж, мэдээллийн нээлттэй байдал хангагдсан байна.	Мэдээллийн сангийн тоо, Вэб хуудсын ашиглалтын хувь	ЗӨСТ ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.5
1.2.9	Зоонозын халдварт өвчнийг тандан судлах, хайгуул хяналт, голомтын төлөв байдлыг тогтоох шинжилгээ хийх.	Байгалийн голомт хяналтын шинжилгээний зааврыг баримталж, байгалийн голомтын төлөв байдал	Байгалийн голомтот зоонозын тархаж буй халдварт өвчний байгалийн голомтын болон	ЗӨСТ	ААНБ-ууд	+	+	+	+	+		-

		тогтоогдсон байна.	хүн амын дундах тархалтыг тоо									
1.2.10	Шинэ сэргэн тархаж байгаа халдварт өвчний дархлаажуулалтын ажлыг сайжруулах, хамралтыг нэмэгдүүлэх.	Дархлаажуулалтын хамралт нэмэгдэж өвчлөлийн тохиолдол буурсан байна.	Өвчлөлийн тохиолдлын тоо, дархлаажуулалтын хамралтын хувь	ЗӨСТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	-	
1.2.11	Хүн амын дунд зоонозын халдварт өвнөөс сэргийлэх эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.	Мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө гарч, тайлагнасан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЗӨСТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	-	
1.3. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг судлан, хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврын уялдаа холбоонд тулгуурлан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх.												
1.3.1	Хүүхдийн байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчтай урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулах, хамтран ажиллах гэрээ байгуулах.	Гэрээ байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.5	
1.3.2	Халдварт бус өвчнийг хянах сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт үнэлгээ зохион байгуулах.	Хяналт үнэлгээ хийгдэж, тайлан гарсан байна.	Жилдээ 2 удаа	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.4	
1.3.3	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжигч боловсролын байгууллага уралдааныг зохион байгуулж, шагнаж урамшуулах.	Эрүүл мэндийг дэмжигч боловсролын байгууллагыг шалгаруулсан байна.	Жилдээ 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна.	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд			+	+	+	0.9	
1.3.4	Өсвөр үе, залууст ээлтэй тусламж үйлчилгээний чиглэлээр зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох.	Өсвөр насны залууст ээлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	2.4	
1.3.5	Халдварт бус өвчин, осол гэмтлийн өнөөгийн байдалд судлагаа хийн, тусламж үйлчилгээний хэрэгцээ, эрсдэлийг тодорхойлж, бодлого боловсруулан хэрэгжүүлэх.	Осол гэмтэлд судалгаа хийж үр дүнг тооцсон тайлан гарсан байна.	Судлагаанаас гарсан зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+	+	+	+	25.0	
1.3.6	Хүн амд илүү анхаарсан үйлчлүүлэгч төвтэй, ээлтэй орчин бий болох үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлж, хамт олны оролцоог дэмжиж хамтран ажиллах.	Эрүүл мэндийн байгууллага хамт олны оролцоог дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулж тайлагнасан байна.	Жилдээ 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна.	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+	+	+	+	0.3	
1.3.7	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй болгон, хэрэгжилтэнд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, урамшуулах, сурталчилах	Байгууллага бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө гаргасан байна.	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ СӨЭМТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.3	

	тогтолцоо бий болгох.										
1.3.8	Чийрэгжүүлэлт нийтийн биеийн тамирын чиглэлээр үйлчилгээ эрхэлдэг байгууллага хамт олны үйл ажиллагаанд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангах.	Хяналт үнэлгээ хийгдэж, тайлан гарсан байна.	Жилдээ 2 удаа	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.3
1.3.9	Халдварт бус өвчний идэвхтэй илрүүлгийг нэмэгдүүлэх, аймгийн албан байгууллагуудад өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах, үр дүнг тооцох.	Идэвхтэй илрүүлгийг нэмэгдүүлэх өдөрлөг аян зохион байгуулсан байна.	Идэвхтэй илрүүлгийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+	+	+	+	0.6
1.3.10	Тамхинаас гаргах, цусны даралт, илүүдэл жинг бууруулах, таргалалтын хам шалтгааныг тодорхойлон эрсдэлтэй бүлгийн хүн амд зориулсан сургалт сурталчилгааны аянг өрнүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах.	Хорт зуршлаас сэргийлэх аян уралдааныг зохион байгуулж, тайлагнасан байна.	Жилдээ 1 удаа	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ СӨӨМТ	ААНБ-ууд	x	x	x	x	x	0.2
1.3.11	Хүүхдийн байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчтай хүүхэд өсвөр насныхны эрүүл мэндийг дэмжих, амны хөндийн өвчлөлийг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулах, эрүүлжүүлэлтийн хяналтыг сайжруулах гэрээ байгуулах.	Хөтөлбөр хэрэгжүүлэх	Хүүхэд өсвөр насныхны амны хөндийн өвчлөл буурсан байна.	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+	+	+	+	0.8
1.3.15	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах.	Ахмад настны эрүүл мэндийн цогц арга хэмжээг үзүүлэх төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ СӨӨМТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.7
1.3.16	Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх, үр дүнг тооцон ажиллах.	Эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+	+	+	+	0.25
1.3.17	Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний талаарх зөвлөмж, зааварчилгааг эхчүүдэд тогтмол өгөх, мэдээллээр хангах	Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний талаарх зөвлөмж боловсруулсан байна.	Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний талаарх мэдлэгийн хувь	ЭМГ	АЗДТГ, ХХАХГ, МХГ, сумын ЗДТГ, цэцэрлэг	+	+	+	+	+	3.0
1.3.18	Айл өрхийн ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдлыг судлан, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог үе шаттай нэмэгдүүлэх, нэгдсэн сан байгуулах ажлыг зохион байгуулах.	Ариун цэврийн стандарт хангасан айл өрх жишиг хороолол шалгаруулж үйл ажиллагааг сурталчилсан байна.	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай өрхийн тоо нэмэгдсэн байна.	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.25
1.3.19	Хүнс хоолны зөв зохистой хэрэглээ, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэгч гэр бүл, хувь хүн хамт олныг дэмжих урамшуулах тогтолцоо бий болгох.	Эрүүл мэндийг дээдлэгч гэр бүлийг шалгаруулж иргэдэд сурталчилсан байна.	Жилдээ 1 удаа	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.18
1.3.18	Айл өрхийн ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдлыг судлан, стандартын	Ариун цэврийн стандарт хангасан	Стандартын шаардлага	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.25

	шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог үе шаттай нэмэгдүүлэх, нэгдсэн сан байгуулах ажлыг зохион байгуулах.	айл өрх жишиг хороолол шалгаруулж үйл ажиллагааг сурталчилсан байна.	хангасан ариун цэврийн байгууламжтай өрхийн тоо нэмэгдсэн байна.									
1.3.19	Хүнс хоолны зөв зохистой хэрэглээ, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэгч гэр бүл, хувь хүн хамт олныг дэмжих урамшуулах тогтолцоо бий болгох.	Эрүүл мэндийг дээдлэгч гэр бүлийг шалгаруулж иргэдэд сурталчилсан байна.	Жилдээ 1 удаа	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.18
1.4. Мэдээлэл технологийн дэвшилтэд тулгуурлан анхан хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоо, орчин нөхцөлийг сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх.												
1.4.1.	Нийгмийн эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг байгуулах, хөгжүүлэх.	Мэдээллийн сан байгуулах бичиг гарч, хэрэгжсэн байна.	Бичиг баримтын хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ, АНЭ СӨЭМТ	ААНБ-ууд		+	+	+	+		0.38
1.4.2.	ЭМЯ, АХБ-ны ЭМСХХ-ын хүрээнд Эмнэлгийн төвлөрсөн ариутгал, хог хаягдлын менежментийг сайжруулах, бэхжүүлэх.	Хог хаягдлын чиглэлээр цогц арга хэмжээ авах төлөвлөгөө, хэрэгжүүлсэн байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.3
1.4.3.	“Нийгмийн эрүүл мэндийн” жишиг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг байгуулах шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангах, үйл ажиллагааг тогтмолжуулах.	“Нийгмийн эрүүл мэндийн” жишиг ЭӨМТ, СЭМТ-ийг байгуулах төлөвлөгөө гарч, тайлагнасан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ, АНЭ СӨЭМТ	ААНБ-ууд				+	+	+	0.28
1.4.4.	“Чадварлаг залуу нийгмийн эрүүл мэндийн ажилтан” аян эрүүл мэндийн газар, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хэмжээнд хэрэгжүүлж шинэ залуу нийгмийн эрүүл мэндийн ажилтан нарын идэвхи санаачилга, ажлын туршлагыг сайжруулах, тогтвортой ажиллах, сэдэлжих бололцоог нэмэгдүүлэн, урамшуулах	Чадварлаг залуу НЭМА болзолт аян зарлаж, шалгаруулсан байна.	Жилдээ 1 удаа	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.75
1.5. Орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах буй аж ахуйн нэгж, байгууллага, хамт олныг бүх талаар дэмжин, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, орчин үеийн олон хэлбэрийг ашиглан зохион байгуулж.												
1.5.1.	Эрүүл мэндийн мэдээлэл сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт, өдөрлөг, аян, үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, үр дүнг тооцох.	Мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө гарч, тайлагнасан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ, С,ӨЭМТ	ААНБ-ууд	+	+	+	+	+		0.38
1.5.2.	Эрүүл мэндийн сайн санааны туслагчын тоог нэмэгдүүлэх, чадваржуулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд татан оролцуулах.	“Эрүүл мэндийн сайн санааны туслагч” хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд		+	+	+	+		0.38

1.5.3.	Иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх кабинетуудыг үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн судлаж, түүнд нийцсэн хариу арга хэмжээ авах.	Судалгаа зохион байгуулах баримт бичиг гарсан байна.	Баримт бичгийн хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ С,ӨЭМТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.8
1.5.4.	Архи, тамхи, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт бус өвчнөөс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийн сайн дурын бүлэг, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэдийн үүсгэл, санаачилгыг дэмжих.	Байгууллага хамт олныг дэмжих, хамтарч ажиллах төлөвлөгөө гарч, тайлагнасан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.6
1.5.5.	Орчин үеийн мэдээлэл технологийн олон хэлбэрийг нийгмийн эрүүл мэндийн бодлоготой уялдуулан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, үр дүнг нь тооцон ажиллах	Төлөвлөгөө гарч, тайлагнасан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.5
1.5.6.	Хүн амын эрсдэлт зан үйлийг бууруулах, эрүүл аж төрөх ёсыг сурталчилах, эрүүл мэндийн аян, уралдаан, тэмцээн, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх.	Эрсдэлт зан үйлийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ СӨЭМТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.38
1.5.7.	Бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг дэмжсэн хамтлаг клуб байгуулах, үүсгэл санаачлагыг дэмжин ажиллах.	Бүх нийтийн эрүүл мэндийг дэмжсэн клуб хамтлагыг дэмжсэн баримт бичиг гарч, хэрэгжсэн байна.	Бичиг баримтын хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.35
1.5.8	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй болгон, хэрэгжилтэнд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, урамшуулах, сурталчилах тогтолцоо бий болгох.	Байгууллага бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө гаргасан байна.	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ЭМЯ, ЗДТГ, ЭМГ, С,ӨЭМТ	ААНБ-ууд	+	+	+	+	+	0.34

Үйл ажиллагааны чиглэл 2.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа					Санхүүжилт /сая төгрөгөөр/
						2017	2018	2019	2020	2021	

2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд уялдуулан зохион байгуулах, тусламж үйлчилгээг хөгжүүлэх.

2.1.1	Хүн амын эрэлт хэрэгцээ, аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байршил, хамрах хүрээ, зураглалыг шинэчлэх.	Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа байршил, хамрах хүрээ хүн амын эрэлт хэрэгцээнд ойртоно.	Шинэчлэгдсэн байршил, хамрах хүрээний зураглалын тоо	ЭМХТ, ЭМЯ, ЭМГ	ЗДТГ, ӨЭМТ, ИТХ		+	+	+	+	16.8
2.1.2	Нарийн мэргэжлийн эмч,	Зорилтот бүлгийн	Тодорхойлсон	ЭМГ	Бүх	+	+	+	+	+	50.0

	мэргэжилтний үзлэг оношилгоог сумын ард иргэдэд, шаардлагатай хүн амд нүүдлийн /явуулын/ амбулаторийн үйлчилгээний багцыг тодорхойлж хэрэгжүүлэх.	хүн амын тусламж үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдал сайжирна.	багц, хүрч үйлчилсэн удаа, хамрагдсан иргэдийн тоо, хувь, өсөлт		түвшний ЗДТГ, СЭМТ							
2.1.3	Хүүхдийн эмчийн хангалтыг сайжруулж, нярайн сэхээн амьдруулах, мэс заслын эмч бэлтгэж, мэргэшсэн эмч тусламжийг үзүүлдэг болох.	Хүүхдийн тусламжийн төрөл нэмэгдэж, тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Хүүхдийн мэс заслын эмч сургагдан, тусламжийг мэргэшсэн эмч үзүүлж байгаа эсэх	ЭМГ, АНЭ	ЗДТГ	+	+	+	+	+		-
2.2. Өрх сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдийг шаардлагатай оношилогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг үе шаттайгаар хангаж, эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэн, эмчилгээ үйлчилгээ авах чирэгдлийг багасгах.												
2.2.1	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг оношилогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, ялангуяа яаралтай тусламж, хэвлийн ЭХО аппарат, лаборатори, нөхөн сэргээх оношилогоо, эмчилгээний нэн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор бүрэн хангах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Стандартын хангалтын хувь	ЭМГ	ЭМЯ, ЗДТГ	+	+	+	+	+		500.0
2.2.2	Гэмтлийн тасгийг өргөжүүлж мэс заслын хагалгааны өрөө, болон С-ARM / зөөврийн рентген аппарат/, Дерматоми /арьс нөхөх/ гэмтлийн хагалгааны иж бүрдэл багажаар хангах.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Худалдана авсан багаж хэрэгслийн тоо	ЭМГ, НЭ	ЗДТГ, ЭМЯ, ЭМХТ		+	+	+	+		250.0
2.2.3	Сум, өрхийн багийн эмч, эх баригчдыг эх, нярайн яаралтай болон нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний урт, богино хугацааны сургалтанд хамруулж, дадлагажуулах	Эмч, эмнэлгийн мэрэгжилтний мэдлэг, ур чадвар, нярайн тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Сургагдсан эмч, эх баригчийн хувь Нярайн тусламжийн чанарын шалгуур	ЭМГ, АНЭ, АЗДТГ	СДЭ, С,ӨЭМТ	+	+	+	+	+		
2.3. Өмчийн хэлбэрээс үл хамааран орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг үйл ажиллагааны нэгдмэл байдлаар эрүүл мэндийн тусламж,												

үйлчилгээ үзүүлдэг болгох.

2.3.1	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай дотор, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн шүд, хүүхэд ба нярайн амбулатори, мэс заслын тусламж үйлчилгээний ачаалал хуваалцах, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх.	Тусламж үйлчилгээний төвлөрөл саарч, хүртээмж нэмэгдэнэ.	Гарсан шийдвэр Гэрээтэй ажиллаж байгаа эмнэлгийн тоо Үзлэг,өвчлөл, нас баралтын /ерэг / үр дүн	ЭМЯ, ЭМГ	ЗДТГ, АНЭ	+	+	+	+	14.0
2.3.2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, төлөвлөлт болон хэрэгжилтэнд хөндлөнгийн үнэлгээг хийж ард иргэдэд тайлагнадаг болох.	Үйл ажиллагааны нэгдмэл байдал, түншлэлд ахиц дэвшил гарч үйл ажиллагаа сайжирна.	Тайлагнасан байдал /тайлан, үзүүлэлт/ Хийгдсэн үнэлгээ, тайлан.	ЭМГ, АЗДТГ	Төр, Хувийн болон ТББ	+	+	+	+	3.5
2.3.3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслэлээр тогтвортой хангах нөхцлийг бүрдүүлж, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар хүртээмж сайжирна.	Гарсан шийдвэр, гэрээ, хамтран ажилласан байгууллагын тоо ГБТ-ийн аргын хангалт, хэрэглээний байдал	ЭМГ, АНЭ	СДЭ, ӨЭМТ, СЭМТ, ЗДТГ	+	+	+	+	3.2
<p>2.4. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааны үялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулан эмнэлгийн тусламж үйлчилгээний чирэгдлийг бууруулах “Үйлчлүүлэгч төвтэй” байж, тусламж, үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан бие даасан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлэх.</p>										
2.4.1	Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх багцыг хэрэгжилтэнд хяналт тавих.	Тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Гарсан эрх зүйн акт	ЭМГ, АНЭ, МХГ	АЗДТГ –ын НХХ Анхан шатны эмнэлгүүд ,ХХЭМБ – ууд	+	+	+	+	-
2.4.2	Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тасагт 4D ЭХО аппарат багаж, тоног төхөөрөмж,	Багаж, тоног төхөөрөмжийн хангалт сайжирч,	Багаж, тоног төхөөрөмжийн хангалтын хувь	ЭМГ, АНЭ	СДЭ, ӨЭМТ, СЭМТ,	+	+	+	+	125.0

	Сурфактант эмийн эмчилгээгээр хангах.	эмчилгээ оношилогооны чадавхи сайжирна.			ЗДТГ ТББ							
2.4.3	Багийн эмчийг явуулын байртай, багийн эмчийн цомогтой болгож, иргэдэд хүрч үйлчлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.	Хөдөөгийн багийн тусламж үйлчилгээний хамралт хүртээмж нэмэгдэнэ.	Явуулын байртай болсон багийн эмчийн тоо	ЭМГ, ЗДТГ	ӨЭМТ, СЭМТ, СДЭ, АНЭ		+	+	+	+		27.3
2.5. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилогоо эмчилгээний үр дүн, тасралтгүй байдлыг хангах, байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлэн сэргийлж болох өвчний хүндрэл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтыг бууруулах.												
2.5.1	Хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж байгаа халдварын бус архаг өвчний оношилгоо, эмчилгээний үр дүнг тооцох.	Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Хамрагдалтийн хувь	ЭМБ, ЭМГ, ЭМНДХ	АНЭ, СЭМТ, СДЭ, ӨЭМТ		+	+	+	+		3.5
2.5.2	Халдварын бус өвчин ялангуяа өвчлөл нас баралтаар тэргүүлж буй зүрх судасны өвчин, тархины цус харвалт, хорт хавдар, осол гэмтэл зэрэг өвчлөл, нас баралтад судалгаа хийх, хариу цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Өвчлөлийн үзүүлэлт	ЭМГ, АНЭ	ЗДТГ, СЭМТ, СДЭ, ӨЭМТ		+	+	+	+		8.0
2.5.3	Эрт илрүүлэг, эмчилгээ, хяналт, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах.	Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж	ЭМГ	АНЭ, СДЭ, ӨЭМТ, СЭМТ		+	+	+	+		2.0
2.6. Тусламж үйлчилгээний анхан болон лавлагаа шатлалд уламжлалт анагаах ухааны оношилогоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх.												
2.6.1	Ахмадын сувилал байгуулна. Тусламж үйлчилгээг өргөжүүлэх.	Ахмадад үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, сайжирна	Ахмадын сувилал байгуулагдсан байна.	ЭМГ, ЗДТГ	АНЭ		+	+	+	+		75.0
2.6.2	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх, шаардлагатай эм хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж, сэтгэл ханмаж сайжирна. Архаг суурь өвчлөл багасна.	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн илэрхийлэл. Өвчлөлийн хувь буурна.	ЭМГ, АНЭ	ЗДТГ		+	+	+	+		35.0

2.6.3	Орон нутгийн байгалийн баялагт түшиглэн, эмчилгээний үр дүн сайтай рашаан, элс, шавар эмчилгээний сувилалуудыг дэмжиж ажиллах, сурталчлах.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Рашаан сувилалын тоо үйлчлүүлэгчдийн тоо	ЭМГ	ХХЭМБ-ууд	+	+	+	+	+	46.0
2.7. Сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.											
2.7.1	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үзүүлэх өдрийн эмчилгээ, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээ, гэрээр үзүүлэх асаргаа сувилгаа, сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, даатгалаас санхүүжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх.	Сувилахуйн тусламжийн хүртээмж сайжирна.	Ажлын үр дүн сэтгэл ханамжийн судалгаа.	ЭМГ, АНЭ	СДЭ, ӨЭМТ, СЭМТ	+	+	+	+	+	-
2.7.2	Эрүүл мэндийн байгууллагад сэтгэл зүйч, хоол зүйч, хөдөлгөөн засалч, сэргээн засалчыг гэрээгээр, цаашид орон тоогоор ажиллуулах асуудлыг шийдвэрлэх.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Орон тоо	ЭМГ, АНЭ, СДЭ, ӨЭМТ, СЭМТ	ЗДТГ		+	+	+	+	32.0
2.7.3	Сувилахуйн жишиг үйлчилгээ бүхий загвар эмнэлгүүдийг шат дараатайгаар бий болгох, хөгжүүлэх.	Сувилахуйн тусламж үйлчилгээний стандартын хэрэгжилт сайжирна.	Эмнэлгийн тоо	АНЭ, СДЭ, ӨЭМТ, СЭМТ	ЗДТГ	+	+	+	+	+	4.0
2.7.4	Хүүхдүүдийн сувилал, хоолны газар байгуулж, суурь эмгэгтэй бага насны хүүхдийг стандартын түвшинд сувилах, нэмэгдэл хоолоор хангах нөхцлийг бүрдүүлэх.	Сувилахуйн тусламжийн чанар сайжирна.	Үйлчлүүлэгчийн тоо	ЭМГ	АНЭ, СДЭ, ӨЭМТ, СЭМТ, ЗДТГ	+	+	+	+	+	5.0
2.8. Орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэргэшсэн эмч нарыг сургаж чадавхижуулах замаар зарим шаардлагатай тусламж, үйлчилгээг аймаг орон нутагт үзүүлдэг болох.											
